



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/145

Улаанбаатар хот

ШУТИС-ийн санхүүжилттэй төсөл сонгон шалгаруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.14, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/145 дугаар тушаалаар баталсан “ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 5.6.2, 7.6 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 4.6.1 дэх заалтыг үндэслэн 2024 онд ШУТИС-ийн санхүүжилттэй төсөл сонгон шалгаруулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Санхүүжилт олгох төслийн сонгон шалгаруулалтыг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулахыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөлийн дарга (Д.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Т.НАМНАН

367041069

ШУТИС-ийн захирлын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 000 дугаартушаалын хавсралт



ШУТИС-ийн санхүүжилттэй төслийн сонгон шалгаруулалтын удирдамж

Зорилго:

ШУТИС-ийн судалгаа, инновацын хөгжилд хувь нэмэр оруулахуйц судалгааны төслүүдийг сонгон шалгаруулж, 2024 онд санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

Төслийн төрөл:


ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, технологийн газраас 2024 онд хэрэгжүүлэх (1) **суурь судалгаа /онолын суурь ШУ-ыг хөгжүүлэх/, (2) технологийн туршилт, зүгшрүүлэлт /судалгааны үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх/-ийн төслийг сонгон шалгаруулж санхүүжүүлнэ.**

Тавигдах шаардлага:

Төсөл нь дараах шаардлага, шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Төсөл мэдүүлэх судалгааны багийн удирдагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны (харьяа хүрээлэнгийн судлаачид хамаарна) доктор буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой профессор, багш, судлаач байна;
2. Төслийн багийн гишүүдийн тоог хязгаарлахгүй бөгөөд төслийн багт ШУТИС-ийн үндсэн болон гэрээт профессор багш, судлаач, ажилтан 2 буюу түүнээс дээш, докторын сургалтад хамрагдаж буй нэг оюутныг заавал оролцуулна;
3. Судалгааны төслийг хэрэгжүүлэх хугацаа суурь судалгаа-15 сар, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл-24 сараас хэтрэхгүй байна;
4. Судалгааны үр дүнг эзэмших, ашиглахыг ШУТИС-д зөвшөөрсөн байна;
5. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний үндсэн зорилгод хүрэх замын зураглал- KPI"-ийн үзүүлэлтүүдэд хувь нэмэр оруулсан байна;

№	Төсөлд тавигдах шаардлага:	
	Суурь судалгаа	Технологийн туршилт, зүгшрүүлэлт
1	ШУТИС-ийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд онолын суурь шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн шийдвэрлэх асуудал нь тодорхой, оновчтой судалгааны арга замыг сонгосон байх;	Урьд өмнө судлагдсан байх бөгөөд үр дүнгээр оюуны өмчийн эрхийн баталгаажилтын гэрчилгээ авсан байх;
2	WoS, Scopus-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр 1-ээс доошгүй өгүүлэл хэвлүүлэх;	Судалгааны үр дүнг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээнд туршин нэвтрүүлэх;
3	Дэвшүүлж буй судалгааны чиглэлээр ШУТИС-д суралцаж буй 1 докторантыг төсөл хэрэгжих хугацаанд урьдчилсан эсвэл жинхэнэ хамгаалалт хийлгэсэн байх;	Төслөөр хөгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетинг болон бизнес төлөвлөгөөг боловсруулан өрсөлдөх чадвар (зах зээл, үр ашиг, түүхий эд материалын талаарх тооцоо, судалгаа)-ийг илэрхийлсэн байх;



4	Судалгааны үр дүнд зохиогчийн эрх, ном сурах бичиг, гарын авлагын аль нэгийг гаргах;	Төслийн судалгаа хөгжүүлэлтийн үе шат 6 сар (бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргах), үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх үе шат 18 сар төслийн нийт үргэлжлэх хугацаа 24 хүртэлх сар байх;
5	Судалгааны үр дүнг ШУТИС-ийн багш, судлаачдын дунд хэлэлцүүлж, түгээн дэлгэрүүлэх;	Төслийг амжилттай хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн чадавх (бусад эх үүсвэрээс хамтарсан санхүүжилт авсан бол давуу тал болох)-тай байх;
6	Төслийн санхүүжилтийн нийт дүн: Эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй 25 сая хүртэлх төгрөг байна.	Төслийн санхүүжилтийн нийт дүн: Эргэн төлөгдөх нөхцөлтэй 50 сая хүртэлх төгрөг байна.

Төслийн материал бүрдүүлэх, төсөл ирүүлэх, шалгаруулах хугацаа

1. **Бүрдүүлэх материал:** Төсөл санаачлагч баг нь доорх материалыг бүрдүүлэн Эрдэм шинжилгээ, технологийн газарын Судалгаа, хөгжүүлэлтийн албанд ирүүлнэ.
 - 1.1 Судалгааны баг нь дэвшүүлэх төслийн саналаа "төсөл мэдүүлэх заавар маягт"-ын дагуу боловсруулж, PDF форматаар research@must.edu.mn цахим хаягаар ирүүлнэ (Материал дутуу ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй);
 - 1.2 Тухайн судалгааны сэдвийн давтагдаагүй байдал, гарах үр дүнгийн төсөөллийн саналыг төслийн удирдагчийн харьяалах бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн хурлын тэмдэглэл;
2. **Материал хүлээн авах:** Төслийн материалыг 2023 оны 10 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хүлээн авна.
3. **Төслийн санал хянах:** Ирүүлсэн төслийн саналын материал бүрэн эсэх, тавьсан шаардлагад нийцэж буй эсэхийг ЭШТГ-ийн Судалгаа, хөгжүүлэлтийн алба хянан магадалгаа хийж, шаардлага хангасан төслүүдийг шалгаруулалтад урина.
4. **Сонгон шалгаруулах:** Шаардлагад нийцсэн төслүүдийг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөлөөр нээлттэй хэлэлцэж, эцсийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

Эрдэмтэн судлаач Та бүхнийг ШУТИС-ийн Захирлын 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн А/145 тоот тушаалын хавсралтаар баталсан "ШУТИС-д Төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам"-ийг баримтлан, удирдамжийн дагуу төслийн баримт бичгийг боловсруулан сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.